Гиван-9 жорын хий, шар, бадганы жишиг итгэлцүүрийг тооцсон дүн

Н.Мөнхбат[1,2], Б.Уганбаяр[2], А.Золжаргал[2], Г.Мөнхзул[2], Ч.Чимэдрагчаа[1,2]

[1]АШУҮИС, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль
[2]Уламжлалт Анагаах Ухаан, Технологийн Хүрээлэн
Цахим хаяг: munkhbat2020mn@gmail.com, Утас: 99187966

Түлхүүр үг:

Уламжлалт анагаах ухаан
Жишиг итгэлцүүр
Элэгний өвчин

Товч утга:

Зорилго: Гиван-9 жорын жишиг итгэлцүүрийг тооцон хий, шар, бадганы гэмд үзүүлэх нөлөөг тогтоох. **Хэрэглэгдэхүүн, арга зүй:** Бие махбод гадаад орчинтойгоо шүтэн барилдах ёсны түгээмэл зүй тогтол ба бүлэглэн шаталж эм найруулах зарчимд үндэслэн УАУ-д хэрэглэж ирсэн эм, эмт бодисын гэмд буюу биеийн ерөнхий төлөвт (өвчинд) нөлөөлөх амтын чадлыг Б.Дагвацэрэн нарын (1996) жишиг итгэлцүүрийг (ЖИ) тооцох аргыг ашигласан. **Үр дүн:** Бид юуны өмнө Гиван-9 жорын найрлагад ордог түүхий эдүүдийн жишиг итгэлцүүрийг тооцоход жорын найрлагад орсон түүхий эдүүд нь шарыг дарах чадалтайгаас гадна Гиван, Зогдор өвс, Гүргэм нь хий дарах, Рүда, Алтанцэцэгийн үр, Барагшин нь бадганыг дарах чадалтай байна. Харин Гиван-9 жорын хий шар бадганыг дарах жишиг итгэлцүүрийг тооцоход шарыг дарах чадал 0.88, хийг дарах чадал 0.55, бадганыг дарах чадал 0.37 байгаа болох нь тогтоогдож уламжлалт заалтуудтайгаа тохирч байна. **Дүгнэлт:** Гиван-9 жорын найрлага дахь эмт бодисууд нь шарыг дарах сэрүүн чадалтай, халууныг арилгах үйлдэлтэй ч гурван гэмд харилцан адилгүйгээр аль алинд нь тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.

Үндэслэл: Дэлхийн улс орнууд ургамлын эмийн ач холбогдлыг өндрөөр үнэлж, зохистой, аюулгүй хэрэглээг дэмжсэн өргөн хүрээт бодлого явуулж ялангуяа уламжлалт жор, ургамалд агуулагдах биологийн идэвхт бодисыг ялган таних, стандартчилах, технологийг боловсронгуй болгоход онцгой анхаарч олон тооны баримт бичиг боловсруулсан байна. Тиймээс манай оронд хэрэглэгдэж байгаа уламжлалт жоруудын гол бүрэлдэхүүн болох ургамлын гаралтай нэгдлүүдийг таних, ялгах, шалгах, стандартчилах, эм судлал, эмнэл зүйн судалгаа явуулахад дээрх түвшингийн шаардлага зайлшгүй тавигдаж байгаа юм.[2,4,5]

Монгол-Төвөдийн уламжлалт анагаах ухаан нь эртний Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны язгуурт багтах бөгөөд онол арга зүйн үндсэн ойлголтууд болох хий, шар, бадган (гэм), эмийн 6 амт, 8 чадал, 17 эрдэм нь аливаа юмс үзэгдлийн түгээмэл язгуур чанар буюу эхлэл гэж үздэг буддизмын гүн ухааны хий, гал, ус, шороо, огторгуй хэмээн нэрийдсэн таван махбодын онолоос урган гарч ирсэн байдаг. Бие махбодын тогтолцоо ба хүрээлэн буй орчны нөлөөг үзэхэд нэг талд нь бие махбодыг хий шар бадганы 20 бэлэг чанарт нөгөө талд нь гадаад орчныг эмийн 8 чадал ба 17 эрдэмд хураангуйлсан байдаг. Уламжлалт анагаах ухаанд эм танг амт, чадал, шингээлт гэсэн гурван үндсэн аргаар найруулж хэрэглэдэг.[2]

Бие махбод ба хүрээлэн буй орчны хамаарлыг ашиглан “эм-тогтолцоо бие-тогтолцоо (гэм) буюу Э=f(Г)” хэмээн томьёолсон. Энэ харьцааг ашиглан эмт бодисын биед (түүний анхдагч элемент болох хий шар бадганд) үзүүлж болох нөлөөг тооцох арга боловсруулсныг эмт бодис ба эмийн хий шар бадганд үзүүлэх нөлөөний жишиг итгэлцүүр хэмээн нэрлэсэн байна.[2,4]

Монгол, Төвөдийн УАУ-нд эмийн амтаар найруулахдаа амтлаг, давслаг, исгэлэн, гашуун, эхүүн, гошуун зэрэг 6 амтын байж болох зохиомжийг тооцсон байдаг. Эмийг амтаар найруулахад тухайн эмийн жоронд орж буй тодорхой амттай эмт бодисыг тооны

болон харьцааны хувьд өөрчлөн хольж хүсэж буй амт чадалтай эмийг бүтээдэг.

Хүн амын халдварт бус өвчлөлийн хоёрдугаарт ордог хоол боловсруулах тогтолцооны өвчин сүүлийн 10 жилийн дунджаар нийт өвчлөлийн 15.5 хувийг эзэлж байна. Монгол улсын хэмжээнд 2019 онд элэгний архаг үрэвсэлт өвчин 43.0 хувь, элэгний хатуурал 32.4 хувийг эзэлж байгаа нь өмнөх жилээс 2.3 хувиар нэмэгдсэн байгаа нь судлаачдын бүтээлд дурдагдсан байна.[6]

Дээрх судалгааныудаас харахад элэгний өвчнийг анагаах, хор гаж нөлөө багатай, өртөг хямд, байгалийн гаралтай эм бэлдмэлийн судалгааг хийх зайлшгүй шаардлага тулгарч байна. Тиймээс бид УАУ-нд элэг бэртэж доргисон, элгэнд цөс дэлгэрсэн, элэгний халуун, бор бадган дэлгэрэхийг анагаах зорилгоор хэрэглэж ирсэн Гиван-9 жорын жишиг итгэлцүүрийг тооцохоор сонгон авлаа.[3.7-13]

Зорилго: Гиван-9 жорын жишиг итгэлцүүрийг тооцон хий, шар, бадганы гэмд үзүүлэх нөлөөг тогтоох

Зорилт:

1. Гиван-9 жорын найрлагад орсон түүхий эдүүдийн жишиг итгэлцүүрийг тооцох
2. Уг жорын жишиг итгэлцүүрийг тооцох

Хэрэглэгдэхүүн, арга зүй: Бие махбод гадаад орчинтойгоо шүтэн барилдах ёсны түгээмэл зүй тогтол ба бүлэглэн шаталж эм найруулах зарчимд үндэслэн УАУ-д хэрэглэж ирсэн эм, эмт бодисын гэмд буюу биеийн ерөнхий төлөвт (өвчинд) нөлөөлөх амтын чадлыг Б.Дагвацэрэн нарын (1996) жишиг итгэлцүүрийг (ЖИ) тооцох аргыг ашигласан.

УАУ-д хэрэглэж ирсэн эм, эмт бодисын гэмд буюу биеийн ерөнхий төлөвт (өвчинд) нөлөөлөх амтын чадлыг жишиг итгэлцүүрийг (ЖИ) тооцох аргаар боловсруулсан бөгөөд ерөнхий томьёонд үндэслэгдсэн болно.


Эмт бодисын жишиг итгэлцүүрийг тооцохын тулд эхлээд тухайн эмт бодисын амт, чадал, эрдмийг холбогдох ном, эх сурвалжаас тодруулсан. Тухайн амтын чадал ба эрдмийн хувь хэмжээг тодорхойлоод гэм тус бүрд харгалзах тоог хооронд нь нэмсэн. Эндээс гарсан тоогоо хий, шар, бадганы үндсэн бэлэг чанарын хувь хэмжээнд хувааж тухайн эмт бодисын жишиг итгэлцүүрийг дараах томьёогоор гаргасан. Эндээс ерөнхий томьёог задалж:

$$ЖИх = \frac{Э}{12х\,Г} \quad ЖИш = \frac{Э}{13х\,Г} \quad ЖИб = \frac{Э}{26х\,Г}$$

ЖИх.ш.б – хий, шар, бадган дарах жишиг итгэлцүүр
Э - эм
Г- гэм (хий, шар, бадган)


Энэ томьёог ашиглан эмийн амтын 8 чадлын хий шар бадганыг дарах жишиг итгэлцүүрийг тооцоход ашигласан.

Үр дүн: Бид юуны өмнө Гиван-9 жорын найрлагад ордог түүхий эдүүдийн жишиг итгэлцүүрийг тооцсон.



Зураг 1. Гиван-9 жорын түүхий эдүүдийн жишиг итгэлцүүрийг тооцсон дүн

Дээрх зургаас харахад Гиван-9 жорын найрлагад орсон түүхий эдүүд нь шарыг дарах чадалтайгаас гадна Гиван, Зогдор өвс, Гүргэм нар нь хий дарах, Рүда, Алтанцэцэгийн үр, Барагшин нь бадганыг дарах чадалтай байгаа юм.



Зураг 2. Гиван-9 жорын жишиг итгэлцүүрийг тооцсон дүн

Дээрх үр дүнгээс харахад Гиван-9 жорын найрлага дахь эмт бодисууд нь шарыг дарах сэрүүн чадалтай, халууныг арилгах үйлдэлтэй байгаа нь харагдаж байна. Мөн гурван гэмд харилцан адилгүйгээр үйлчилж байгаа бөгөөд эдгээрээс шар махбодыг илүү сайн дарж, дараа нь хий махбодыг дарах нөлөө үзүүлж байгаа ч бадган махбодод тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаагаас харахад уламжлалт эмүүд нь махбодын тэнцвэрийг алдагдуулахгүйгээр өвчнийг анагаах үйлдэл үзүүлдэг болох нь харагдаж байна.

Хэлцэмж: Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага болон олон улсын хүрээнд ургамлын эмийн ач холбогдлыг өндрөөр үнэлж, зохистой, аюулгүй хэрэглээг хөхүүлэн дэмжих өргөн хүрээт бодлого явуулж байгаа билээ. Ялангуяа уламжлалт жор, ургамалд агуулагдаж байгаа биологийн идэвхт бодисыг ялган таних, чанарыг шалгах, технологийг боловсронгуй болгохыг онцгойлон анхааруулж байгаа. Тиймээс манай оронд өргөн хэрэглэж байгаа уламжлалт жор болох Гиван-9-ын хими, эм судлал, эмнэл зүйн судалгаа дорвитой хийгдээгүй байсныг бид сонгон авч судалсан.[14]

Монгол-Төвөдийн уламжлалт анагаах ухаан нь эртний Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны язгуурт багтах бөгөөд онол арга зүйн үндсэн ойлголтууд болох хий, шар, бадган (гэм), эмийн 6 амт, 8 чадал, 17 эрдэм нь аливаа юмс үзэгдлийн түгээмэл язгуур чанар буюу эхлэл гэж үздэг буддизмын гүн ухааны хий, гал, ус, шороо, огторгуй хэмээн нэрийдсэн таван махбодын онолоос урган гарч ирсэн байдаг. Бие махбодын тогтолцоо ба хүрээлэн буй орчны нөлөөг үзэхэд нэг талд нь бие махбодыг хий шар бадганы 20 бэлэг чанарт нөгөө талд нь гадаад орчныг эмийн 8 чадал ба 17 эрдэмд хураангуйлсан байдаг.[2]

Хий шар бадганы 20 бэлэг чанар ба эмийн 17 эрдэм хоорондын хамаарлыг арга билгийн үүднээс хооронд нь хамаатуулж хэрхэн уялдуулсныг Хүснэгт 18-аас харж болно. Бие махбод ба хүрээлэн буй орчны энэ хамаарлыг ашиглан "эм-тогтолцоо бие-тогтолцоо (гэм) буюу Э=f(Г)" хэмээн томьёолсон.

Энэ харьцааг ашиглан эмт бодисын биед (түүний анхдагч элемент болох хий шар бадганд) үзүүлж болох нөлөөг тооцох арга боловсруулсныг эмт бодис ба эмийн хий шар бадганд үзүүлэх нөлөөний жишиг итгэлцүүр хэмээн нэрлэсэн байна.[2,4]

Монгол, Төвөдийн УАУ-нд эмийн амтаар найруулахдаа амтлаг, давслаг, исгэлэн, гашуун, эхүүн, гошуун зэрэг 6 амтны байж болох зохиомжийг тооцсон байдаг. Эмийг амтаар найруулахад тухайн эмийн жорд орж буй тодорхой амттай эмт бодисыг тооны болон харьцааны хувьд өөрчлөн хольж хүсэж буй амт чадалтай эмийг бүтээдэг.[2.4.5]

УАУ-нд олон төрлийн түүхий эдээр эмчилгээний жороо зохиохдоо бүрэлдэхүүнээ удирдах голлогч эм ба туслах эм гэсэн хэсэгт хуваах зарчим баримталдаг. Удирдах голлогч эм нь тухайн жорын үндсэн үйлдлийг үзүүлдэг буюу аливаа өвчин эмгэг, өвчилсөн оронд нь чиглэсэн үйлдэлтэй байдаг бол туслах эм нь үндсэн үйлдлийг дэмжих, хорон нөлөөг сулруулах зэрэг өөр нэмэлт үйлдэл үзүүлэх үүрэгтэйгээр жорын бүрэлдэхүүнд ордог ажээ.[2,7]

Монгол, Төвөд, Аюурведийн анагаах ухаанд эм танг найруулах, найруулсан эмийг эмчилгээнд хэрэглэхэд баримталдаг нэг үндсэн зарчим бол биеийн "Анхдагч түгээмэл чанар" болох гурван гэмийн бэлгэ чанарын ихсэж, багасаж эсвэл хямарч өөрчлөгдсөнийг харгалзан түүнд тохирсон амт, чадал, эрдмийн харьцааг агуулсан эмийг буй болгон хэрэглэх явдал юм. Нөгөө талаар олон найрлагатай эм танг бүлэглэн шаталж найруулах үед уг эмийн найрлагад өвчний голлон байрших эд эрхтэн буюу орныг түүнчлэн өвчний язгуурын мөн чанарт нөлөөлөх идэвхтэй эмт бодисыг нэмж өгсөн болох нь бүлэглэн шаталж найруулсан жорыг задлан шинжилсэн дүнгээс харагддаг байна.

Олон найрлагат жорын нэг жишээ болох бидний судалгааны объект Гиван-9 жор нь нийт 9 төрлийн эмт бодисоос бүрдэнэ. Уг жорын найрлагад Гиван, Өвсөн гүргэм, Зогдор өвс, Сибирь удвал, Улаан башига, Дэгд, Барагшин, Рүда, Алтанцэцгийн үр зэрэг түүхий эдүүд орсон байдаг.[1,7,11,13]

Тус жорын гол найрлага болох Гүргэм (*Carthamus tinctorius* L.) нь эрт дээр үеэс цус шарын халууныг арилгах, цус тогтоох үйлдлээр хэрэглэгдэж ирсэн. Түүний найрлага дахь эмт бодисуудын жишиг итгэлцүүрийг тооцсон дүнгээс үзэхэд эмт бодисууд нь ихэнх нь шарыг дарах чадалтай бөгөөд Барагшин, Зогдор өвс нь бадганыг дарах чадалтай. Харин Гиван-9 жорын хувьд цус шарыг халууныг дарах дарах чадал нь 0.88 байсан бол бадганыг дарах чадал нь 0.37, хийг дарах чадал нь 0.55 байгаа бөгөөд эндээс харахад уг танг уламжлалт анагаах ухаанд элэг дэлгэрэх, элэг бүдүүрэх, хор харших, элэг доройтох гэх мэт хурц архаг явцтай элэгний өвчнүүдийн үед хэрэглэгддэг байсантай тохирч байна. Өвсөн гүргэм нь (*Carthamus tinctorius* L.) элэгний эсийн гэмтлийн үед элгийг хорт бодисоос хамгаалах, хордлогот гепатитын улмаас ихэссэн ШФ, АлАТ, АсАТ, ЛДГ зэргийг бууруулдаг, цусны бүлэгнэлтийг тэнцвэржүүлдэг идэвхтэй бөгөөд элэгний халууныг арилгахад голчлон хэрэглэгддэг. Түүнд их хэмжээгээр агуулагдах А крозин нь хавдрын үхжилийн хүчин зүйлийг (TNF-α) дарангуйлах замаар эсийг хамгаалж, чөлөөт радикалын хуримтлалыг сааруулах ба глутатион с трансформац (GSH) антиоксидант энзимийг идэвхжүүлдэг болох нь илэрсэн байна.[1,7]

Дүгнэлт:

1. Гиван-9 жорын найрлагад илүү шарыг дарах сэрүүн, мохдог чадалтай, гашуун амттай түүхий эдүүд их орсон байна.
2. Уг жорын хий шар бадганыг дарах жишиг итгэлцүүрийг тооцоход шарыг дарах чадал 0.88, хийг дарах чадал 0.55, бадганыг дарах чадал 0.37 байгаа болох нь тогтоогдож уламжлалт заалтуудтайгаа тохирч байна.

Талархал: Энэхүү судалгааны ажлыг хийхэд гүн туслалцаа үзүүлж, дэмжиж тусалсан АШУҮИС-ийн МАУОУС-ийн эрдэмтэн багш нар, УАУТХ-ийн нийт хамт олон болон зөвлөх багш АУ-ны доктор, профессор Ч.Чимэдрагчаа, удирдагч багш АУ-ны доктор Б.Ууганбаяр нартаа баярлалаа.

Ном зүй:

1. *Лигаа У нар. Монгол орны эмийн ургамлыг өрнө дорнын анагаах ухаанд хэрэглэхүй. Улаанбаатар: JKC printing; 2005 он.*
2. *Дагвацэрэн Б, Монгол Төвд анагаах ухааны онол арга зүйн үндэс. УБ хот. 1996. х.х. 5.5*
3. *Анагаах Ухааны Дөрвөн Үндэс, 36-р бүлэг, ӨМӨЗО, Хөх хот: 1997 он.*
4. *Анагаах ухааны нэвтэрхий толь 2001 он*
5. *Амарзаяа Д нар. Уламжлалт эм найруулах аргын зарим онцлог, судалгааны үр дүн. АУ-ы докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар хот. 2017 он.*
6. *Эрүүл мэндийн хөгжлийн төв. Эрүүл мэндийн үзүүлэлт 2019. х.139-143.*
7. *Олдох С, Цэрэнцоо Б, Батхуяг П. Монгол эмийн судлал. 2009 он, Улаанбаатар хот,*
8. *С.Сээсрэгдорж, Ч.Чимэдрагчаа, С.Хишигжаргал, Д.Цэрэндагва, Б.Чулуунчимэг. Монголын уламжлалт анагаах ухааны өвчнийг анагаах увидас. Улаанбаатар хот, 2005 он,*
9. *Монгол Анагаах Ухааны Дотор Эмнэлгийн Судлал. 2.3-р бүлэг, Элэгний өвчин. ӨМӨЗО, Хөх хот: Үндэсний хэвлэлийн хороо; 1987 он*
10. *Алтансүмбэр. Монгол эмийн шүлэглэл. Хөх хот: Үндэсний хэвлэлийн хороо; 1995.*
11. *Данзанпунцаг. Рашаан эмийн зүйл ялгал, мөн чанар, чадал, нэрийг дэлгэрэнгүй өгүүлсэн хиргүй болор эрхи хэмээгдэх*

оршвой. Модон эмийн үрийн зүйл. Хөх хот: Өвөр Монголын шинжлэх ухаан танин мэдэхүйн хэвлэлийн хороо; 2001 он.
12. Жамбалдорж. Анагаан үйлдэгч рашааны нуурыг эндүүрэлгүй танин барих урлах ухааны толин дор дүр тодруулсан гайхамшигт нүдэн чимэг хэмээх судар оршвой. (Монгол эм зөв таних толь). Модон эмийн үрийн зүйл. Хөх хот: Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо; 1998 он.
13. Лувсанчүлтэм. Эм таних ухаан. Хөх хот: Үндэсний хэвлэх хороо; 1998 он.
14. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага. Хепатитын В вирүсийн халдварыг эрт илрүүлэх, оношлох, эмчлэх удирдамж. 2017 он.

Conclusion of reference wind, bile and phlem index of Giwa-9 has calculated

Munkhbat.N[1,2], Uuganbayar.B[2], Munkhzul.G[2], Zoljargal.A[2], Chimedragchaa.Ch[1,2]

[1]School of International Mongolian Medicine, MNUMS
[2]Institute of Traditional Medicine and Technology
E-mail: munkhbat2020mn@gmail.com, Tel: 99187966

Methods: Based on the common logical principles of relations between the human body and environment and the principles of the compounding medicine by groups, we used the method of estimate the reference index of the potency of the taste in which traditional medicines impact to diseases (Dagvatseren.B et al 1996).
Results: Reference index of Giwa-9 has calculated, it contains main raw materials which are healing bile. Also some raw materials have warm potency of healing wind and phlegm. Reference index of Giwa-9 has calculated by healing bile RI=0.88, healing phlegm RI=0.37 healing wind RI=0.57. It corresponds to the indication of the oriental medicine.
Conclusion: Raw materials in Giwa- 9 have the cold potency of healing bile and to eliminate warm. It impacts on 3 elements fellowlessly.

Key words: Giwa-9, traditional medicine, liver disease